



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 22 өдөр

Дугаар А/169

Арвайхээр

Тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.б, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.18 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх, тусгай зөвшөөрөл олгох комиссын 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу тусгай зөвшөөрөл сунгах нэр бүхий 4 эмнэлгүүдийг нэгдүгээр, тусгай зөвшөөрөл шинээр олгох сунгах нэр бүхий 3 эмийн сангуудыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг сумдын Засаг дарга, аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газар (Д.Шиваанүрдэв), Мэргэжлийн хяналтын газар (С.Дуламсүрэн), Цагдаагийн газар (О.Ганбат) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100361

Аймгийн Засаг даргын 2020 оны 04
дугаар сарын 22-ны өдрийн 169 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ, ЭМНЭЛЭГИЙН НЭР, ЧИГЛЭЛ, ОЛГОХ
ХУГАЦАА

д/д	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Тусгай зөвшөөрөл олгох хэлбэр	Олгох хугацаа	Тусгай зөвшөөрлийн дугаар
1	Ариунсанаа эмнэлэг	Эмнэлгийн тусламж үйлчилгээ эрхлэх (Эмэгтэйчүүд, дотор, уламжлалт анагаах ухаан, мэдрэл, шүдний оношилгоо, эмчилгээ, хиймэл шүд, амбулатори, өдрийн эмчилгээ)	Арвайхээр сум	Сунгах	5 жил	
2	Үйлст эмнэлэг	Дотрын үүдэн эмнэлэг	Арвайхээр сум	Сунгах	5 жил	
3	Тод дүрс эмнэлэг	Дүрс оношилгооны үүдэн эмнэлэг	Арвайхээр сум	Сунгах	5 жил	
4	Жаргалант багийн эмнэлэг	Эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ	Уянга сум Жаргалант баг	Сунгах	5 жил	

Аймгийн Засаг даргын 2020 оны 04
дугаар сарын 28-ны өдрийн 1169 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ, ШИНЭЭР ОЛГОХ ЭМИЙН САНГУУДЫН НЭР,
ЧИГЛЭЛ, ХУГАЦАА

д/д	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Байршил	Тусгай зөвшөөрөл олгох хэлбэр	Олгох хугацаа	Тусгай зөвшөөрлийн дугаар
1	Намуун энх хувийн хэвшлийн эмийн сан	Нийтийн үйлчилгээтэй эмийн сан	Арвайхээр сум	Сунгах	5 жил	
2	Энх Оргил жаз хувийн хэвшлийн эмийн сан	Нийтийн үйлчилгээтэй эмийн сан	Бат-Өлзий сум	Сунгах	5 жил	
3	Очир хулд хувийн хэвшлийн эмийн сан	Нийтийн үйлчилгээтэй эмийн сан	Арвайхээр сум	Шинээр олгох	3 жил	